



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 03 сарын 23 өдөр

Дугаар А/Н7

Чингис хот

Мал амьтны сэг зэм устгал, орчны
халдваргүйтгэлийн ажлыг зохион байгуулж,
хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 7.3.2, 7.3.3, 7.3.4, 7.3.6 дахь заалт, Монгол Улсын Ерөнхий сайдын 2021 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 01 дүгээр албан даалгаварыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Өвчнөөр болон зүй бусаар үхэж хорогдсон мал, амьтны хүүр, сэг зэмийг устгаж, халдваргүйтгэх ажлыг Мал эмнэлгийн байгууллагын заавар, зөвлөмжийн хүрээнд Мал эмнэлгийн тасаг, үйлчилгээний нэгжүүдтэй хамтран орон нутгийн малчид, иргэдийн оролцоотойгоор 2021 оны 4 дүгээр сарын 01-ний өдрөөс 2021 оны 5 дугаар сарын 15-ны өдөр хүртэлх хугацаанд зохион байгуулсугай.


2. Сэг зэм устгал, орчны халдваргүйтгэлийн ажлыг зохион байгуулахад 1815710 /нэг сая найман зуун арван таван мянга долоон зуун арав/ төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

3. Хөрөнгө зарцуулалтын тооцоог хавсралтаар баталсугай.

4. Харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд үр дүнтэй зохион байгуулж, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг сумдын Засаг дарга нарт, удирдлага, мэргэжил арга зүйн заавар зөвлөмж, тусгай зориулалтын автомашин, тоног төхөөрөмж, эмийн бодис, халдвар хамгааллын хувцас хэрэгслээр хангаж гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Мал эмнэлгийн газар /Н.Анхбаяр/, Мэргэжлийн хяналтын газар "Б.Сүнгээ", Харгуй ТӨХК /Н.Болдбаатар/-д тус тус үүрэг болгосугай.

5. Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн бусад арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /С.Нямдаваа/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



ЦИДЭРБАТ

231010417

Аймгийн Засаг даргын 2021 оны
 ...03... дугаар сарын ...23... өдрийн ...А./...
 дугаар захирамжийн хавсралт



Зардлын тооцоо

№	Сумын нэр	Сэг зэм устгалын хяналтын зардал							Нийт мөнгөн дүн
		Ажиллах өдөр/хүн	Нийт томилолт /26500 төг/	Сум хооронд явах км	Багуудад ажиллах км	Нийт км	Зарцуулах шатахун	Шатахууны үнэ	
3	Баянмөнх	2/3	159000	100	50	150	26	39525	198525
4	Дархан	2/3	159000	45	50	95	16	25033	184033
5	Дэлгэрхаан	2/3	159000	90	50	140	24	36890	195890
6	Жаргалтхаан	2/3	159000	45	50	95	16	25033	184033
8	Өмнөдэлгэр	2/3	159000	45	100	145	25	38208	197208
13	Норовлин	2/3	159000	275	50	325	55	85638	244638
14	Батноров	2/3	159000	100	50	150	26	39525	198525
15	Баян-Овоо	2/3	159000	65	50	115	20	30303	189303
17	Хэрлэн	2/3	159000	145	100	245	42	64558	223558
Нийт дүн		18/3	1431000	910	550	1460	248	384710	1815710